

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг дахь Гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/004/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Золоо

Утас: 70453799, Цахим хаяг: Zoloot@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
4. Аудитын тайлан	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.10. № УВА-2026/004/НА-СТА-ТДС
танай _____-ны № _____-т

УВС АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Т.ТӨРТӨГТОХ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Увс аймаг дахь Гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймаг дахь Гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050104



NATIONAL BUREAU OF STANDARDS
TECHNICAL NOTE 1070-1

1975-1976
NBS MONOGRAPH 1070-1
NBS MONOGRAPH 1070-1
NBS MONOGRAPH 1070-1

1070-1
1070-1

1070-1
1070-1

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>162,396,179.00</u>	588,932,845.00
33	АВЛАГА	-	198,000.00
335	Бусад авлага	-	198,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	198,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	162,396,179.00	588,734,845.00
351	Түүхий эд материал	112,963,519.00	133,302,403.00
35110	Тусгай зориулалттай материал	112,963,519.00	133,302,403.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,395,000.00	1,395,000.00
354	Хангамжийн материал	37,077,660.00	446,077,442.00
35410	Бичиг хэргийн материал	314,700.00	314,700.00
35420	Аж ахуйн материал	13,914,510.00	431,827,842.00
35470	Бусад хангамжийн материал	22,848,450.00	13,934,900.00
35600	Мал амьтад	10,960,000.00	7,960,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,682,601,672.02</u>	29,750,880,586.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,682,601,672.02	29,750,880,586.49
392	Биет хөрөнгө	8,301,984,089.46	29,401,548,654.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,114,226,579.81	23,533,811,715.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(272,925,468.93)	(366,281,135.07)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	555,618,000.00	555,618,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(252,434,666.88)	(331,259,666.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,760,693,038.22	10,501,041,237.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,131,447,678.63)	(4,931,099,317.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	639,830,054.72	629,113,672.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(111,575,768.85)	(189,395,851.77)
393	Биет бус хөрөнгө	380,617,582.56	349,331,932.08
39301	Програм хангамж	179,900,759.26	179,900,759.26
39302	Хуримтлагдсан элэгдэл	(70,400,983.70)	(101,686,634.18)
39303	Бусад биет бус хөрөнгө	271,117,807.00	271,117,807.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,844,997,851.02</u>	<u>30,339,813,431.49</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>16,303,714.00</u>	<u>75,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,303,714.00	75,000.00
413	Өглөг	16,303,714.00	75,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	75,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,828,694,137.02</u>	<u>30,339,738,431.49</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,828,694,137.02	30,339,738,431.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,836,065,647.36	1,836,065,647.36
51101	Өмч: - төрийн	1,836,065,647.36	1,836,065,647.36
512	Хуримтлагдсан үр дүн	6,792,586,687.40	28,303,630,981.87
51210	Өмнөх үеийн үр дүн	6,565,998,667.20	6,792,586,687.40
51220	Тайлант үеийн үр дүн	226,588,020.20	21,511,044,294.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200,041,802.26	200,041,802.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,844,997,851.02</u>	<u>30,339,813,431.49</u>

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,796,921,793.85	27,102,670,018.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,467,037,597.85	23,632,439,478.37
120	Нийтлэг татварын бус орлого	2,467,037,597.85	23,632,439,478.37
120005	Түрээсийн орлого	310,000.00	205,000.00
120009	Бусад орлого	2,465,972,597.85	23,632,234,478.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,329,884,196.00	3,470,230,540.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,329,884,196.00	3,470,230,540.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,328,384,196.00	3,456,230,540.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,500,000.00	14,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,172,651,289.47	5,588,618,390.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,172,651,289.47	5,588,618,390.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,649,348,584.42	5,148,555,407.02

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,995,835,592.86	2,311,555,726.10
210101	Үндсэн цалин	1,698,645,092.86	1,939,330,726.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	297,190,500.00	372,225,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	257,512,379.82	298,344,121.89
210201	Тэтгэврийн даатгал	179,601,062.44	207,429,963.62
210202	Тэтгэмжийн даатгал	18,688,854.05	24,184,699.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,969,287.02	12,449,422.13
210204	Ажилгүйдлийн даатгал	7,824,290.74	10,908,439.90
210205	Эрүүл мэндийн даатгал	37,428,885.57	43,371,597.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,615,050.78	243,964,693.46
210301	Гэрэл, цахилгаан	112,387,190.58	167,031,715.66
210302	Түлш, халаалт	60,760,234.20	69,995,236.80
210303	Цэвэр, бохир ус	1,467,626.00	6,937,741.00
2104	Хангамж, бараа материалын зардал	127,123,680.49	83,001,897.00
210401	Бичиг хэрэг	8,157,700.00	1,739,600.00
210402	Тээвэр, шатахуун	63,390,850.00	59,962,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,438,760.49	1,361,797.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	337,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,799,370.00	19,537,750.00
2105	Нормативт зардал	10,140,050.00	1,648,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,140,050.00	1,648,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,142,870.00	37,015,070.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	58,676,220.00	9,282,120.00
210604	Урсгал засвар	76,486,650.00	27,732,950.00
2107	Томилолт, зочны зардал	16,497,500.00	2,628,500.00
210702	Дотоод албан томилолт	16,497,500.00	2,628,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,225,531.00	33,671,400.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,755,584.00	23,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	617,627.00	564,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	145,000.00	143,500.00
210807	Газрын төлбөр	1,807,320.00	1,941,160.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	680,000.00	4,802,116.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,903,255,929.47	2,136,725,398.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,775,000.00	5,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,891,480,929.47	2,131,725,398.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	523,302,705.05	440,062,983.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	280,129,196.00	53,335,999.96
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	245,244,200.00	53,335,999.96
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	242,230,309.05	386,726,983.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	242,230,309.05	386,726,983.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	624,270,504.38	21,514,051,627.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	397,682,484.18	3,007,333.33
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	397,682,484.18	3,007,333.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(397,682,484.18)	(3,007,333.33)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	226,588,020.20	21,511,044,294.47

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,330,194,196.00	3,470,435,540.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	310,000.00	205,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	310,000.00	205,000.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	205,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	205,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,329,884,196.00	3,470,230,540.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,329,884,196.00	3,470,230,540.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,328,384,196.00	3,456,230,540.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,500,000.00	14,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,330,194,196.00	3,461,735,540.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,330,194,196.00	3,461,735,540.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,806,891,490.95	3,021,672,556.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,978,948,303.79	2,327,982,440.10
210101	Үндсэн цалин	939,163,370.24	1,121,843,110.53
210102	Нэмэгдэл	521,316,545.31	602,275,820.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	312,174,354.70	399,786,684.07
210104	Урамшуулал	206,294,033.54	204,076,825.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,095,954.89	298,344,121.89
210201	Тэтгэврийн даатгал	179,601,062.44	207,429,963.83
210202	Тэтгэмжийн даатгал	18,688,854.05	24,184,699.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,969,287.02	12,449,422.06
210204	Ажилгүйдлийн даатгал	9,167,890.01	10,908,439.64
210205	Эрүүл мэндийн даатгал	36,668,861.37	43,371,596.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,615,050.78	243,964,693.46
210301	Гэрэл, цахилгаан	112,387,190.58	167,031,715.66
210302	Түлш, халаалт	60,760,234.20	69,995,236.80
210303	Цэвэр, бохир ус	1,467,626.00	6,937,741.00
2104	Хангамж, бараа материалын зардал	129,198,430.49	76,849,747.00
210401	Бичиг хэрэг	8,136,500.00	1,739,600.00
210402	Тээвэр, шатахуун	63,390,850.00	59,962,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,438,760.49	1,361,797.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	972,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	55,260,320.00	13,385,600.00
2105	Нормативт зардал	9,792,300.00	1,648,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,792,300.00	1,648,600.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	199,198,420.00	19,560,170.00
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,366,300.00	5,292,120.00
210604	Урсгал засвар	131,201,220.00	14,268,050.00
2107	Томилолт, зочны зардал	16,497,500.00	2,628,500.00
210702	Дотоод албан томилолт	16,497,500.00	2,628,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,545,531.00	28,869,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,755,584.00	23,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	617,627.00	564,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	145,000.00	143,500.00
210807	Газрын төлбөр	1,807,320.00	1,941,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,000,000.00	21,825,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,000,000.00	21,825,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	523,302,705.05	440,062,983.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	522,359,505.05	440,062,983.55
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	245,244,200.00	53,335,999.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	242,230,309.05	386,726,983.59
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	119,772,420.00	8,700,000.00
22	Хөрөнгийн зардал	119,772,420.00	8,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	119,772,420.00	8,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан	119,772,420.00	8,700,000.00
4	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(119,772,420.00)	(8,700,000.00)

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,836,065,647.36	200,041,802.26	6,565,998,667.20	8,602,106,116.82

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,836,065,647.36	200,041,802.26	6,565,998,667.20	8,602,106,116.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн			226,588,020.20	226,588,020.20
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,836,065,647.36	200,041,802.26	6,792,586,687.40	8,828,694,137.02
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,836,065,647.36	200,041,802.26	7,019,174,707.60	8,828,694,137.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,836,065,647.36	200,041,802.26	6,792,586,687.40	8,828,694,137.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			21,511,044,294.47	21,511,044,294.47
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,836,065,647.36	200,041,802.26	28,303,630,981.87	30,339,738,431.49

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,557,285,300.00	3,470,435,540.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,557,285,300.00	3,470,435,540.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,503,949,300.00	3,030,372,556.45

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,700,959,800.00	2,327,982,440.10
210101	Үндсэн цалин	1,324,795,600.00	1,121,843,110.53
210102	Нэмэгдэл	653,528,300.00	602,275,820.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	508,036,400.00	399,786,684.07
210104	Урамшуулал	214,599,500.00	204,076,825.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	371,841,700.00	298,344,121.89
210201	Тэтгэврийн даатгал	252,981,500.00	207,429,963.83
210202	Тэтгэмжийн даатгал	44,439,600.00	24,184,699.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,535,900.00	12,449,422.06
210204	Ажилгүйдлийн даатгал	12,413,300.00	10,908,439.64
210205	Эрүүл мэндийн даатгал	49,471,400.00	43,371,596.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,705,000.00	243,964,693.46
210301	Гэрэл, цахилгаан	167,551,300.00	167,031,715.66
210302	Түлш, халаалт	70,004,400.00	69,995,236.80
210303	Цэвэр, бохир ус	7,149,300.00	6,937,741.00
2104	Хангамж, бараа материалын зардал	87,955,600.00	76,849,747.00
210401	Бичиг хэрэг	5,979,400.00	1,739,600.00
210402	Тээвэр, шатахуун	65,000,000.00	59,962,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,495,800.00	1,361,797.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,195,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,285,400.00	13,385,600.00
2105	Нормативт зардал	9,958,100.00	1,648,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,958,100.00	1,648,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,303,500.00	28,260,170.00
210602	Тавилга	8,700,000.00	8,700,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,974,900.00	5,292,120.00
210604	Урсгал засвар	19,628,600.00	14,268,050.00
2107	Томилолт, зочны зардал	2,628,500.00	2,628,500.00

210702	Дотоод албан томилолт	2,628,500.00	2,628,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,421,100.00	28,869,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,090,400.00	23,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	799,600.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	895,900.00	564,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	144,300.00	143,500.00
210807	Газрын төлбөр	1,990,900.00	1,941,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,176,000.00	21,825,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,000,000.00	21,825,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	176,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,336,000.00	440,062,983.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,336,000.00	440,062,983.55
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	53,336,000.00	53,335,999.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	386,726,983.59
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,543,285,300.00	3,456,435,540.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,542,985,300.00	3,456,230,540.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,542,985,300.00	3,456,230,540.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	300,000.00	205,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	205,000.00

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДІН		14,000,000
УРСГАЛ ЗАРДАЛ		14,000,000
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		14,000,000
Хангамж, бараа материалын зардал		3,300,000
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,300,000
Эд хогшил, урсгал засварын зардал		8,700,000
Тавилга		8,700,000
Бараа үйлчилгээний бусад зардал		2,000,000
Бараа үйлчилгээний бусад зардал		2,000,000

/төгрөгөөр/

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймаг дахь Гаалийн газар нь “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэх” гэсэн зорилгын дор “Дэвшилтэт техник, технологид суурилсан, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээ үзүүлж, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэгч гаалийн байгууллага болох” үйл ажиллагааны чиглэл зорилт тавин ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймаг дахь Гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймаг дахь Гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,494,815.6 мянган төгрөгөөр буюу 243 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	198.0	198.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	162,396.2	588,734.9	426,338.7
Үндсэн хөрөнгө	8,682,601.6	29,750,880.6	21,068,278.9
Нийт хөрөнгө	8,844,997.8	30,339,813.4	21,494,815.6
Өр төлбөр	16,303.7	75.0	-16,228.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,828,694.1	30,339,738.4	21,511,044.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,844,997.8	30,339,813.4	21,494,815.6

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 198.0 мянган төгрөг болж өссөн нь нийгмийн даатгалд илүү төлөлттэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 588,734.9 мянган төгрөг болж 426,338.7 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, тусгай зориулалттай материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 29,750,880.6 мянган төгрөг болж 21,068,278.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8,700.0 мянга, ГЕГ-аас 23,199,041.7 мянган төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн, тайлант онд 2,131,725.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 55,054.7 мянган төгрөгийг үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 30,339,738.4 мянган төгрөг болж 21,511,044.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,233,403.0 мянга, нийт зарлагыг 2,233,403.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,154,542.0 мянган төгрөгөөр өсгөж 3,387,945.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2025 оны хагас жилд гэрэл цахилгааны тогтмол зардлын нэгжийн үнэ өссөн, албан хаагчдын орон тоо нэмэгдсэн, Боршоо, Тэс хилийн боомтуудын шалган нэвтрүүлэх байранд урсгал засвар үйлчилгээ хийх гүний гаалийн шинэ конторын байрны ашиглалтын болон харуул хамгаалалтын зардал, улсын хил дээр 5 жил ажилласан гаалийн улсын байцаагчийн тэтгэмж олгох зэрэг зардал өссөнөөс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 155,340.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,543,285.3 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,069,708.6 мянган төгрөг буюу 88.9 хувийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70205-Татвар хураалт, орлого бүрдүүлэлт 80101-Үндсэн үйл ажиллагаа	3,469,948.9	2,996,372.6	479,576.3	88.2%
2	80219- Харуул хамгаалалтын зардал	20,000.4	20,000.0	0.4	99.99%
3	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	53,336.0	53,335.9	0.1	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗДНХ-өөс 14,000.0 мянга, түрээсийн орлого 205.0 мянга, нийт 14,205.0 мянган төгрөг төвлөрснөөс тавилга эд хогшил зардалд 8,700.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 3,300.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 205.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 2 тендерийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна. Үүнд шатах тосох материал нийлүүлэх 60,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулан шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан ажилласан байна. Харин түлш халаалтын 52,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг 3 удаа зохион байгуулсан байна. Түлш халаалтын

тендерт оролцогч орж ирээгүй тул өөрсдийн тээврийн хэрэгслээр Боршоо, тэс боолт руу нүүрс тээвэрлэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймаг дахь Гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Золоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь Гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 5,172,651.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 51,726.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,588,618.4 мянган төгрөгийн 1 хувиар 55,886.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 44,708.9 мянган төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймаг дахь Гаалийн газрын төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамж		-	Байгууллагын үйл ажиллагаанд 181,000.5 мянган төгрөгийн программ хангамж ашиглаж байна. Тайлант онд программ хангамж ашиглалттай холбоотой зардал гараагүй байна.
2	Унаа, хоолны зардал	14,553.0	14,979.6	2025 онд албан хаагчдад хоолны зардлыг 14,553.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 14,979.6 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар		-	Сургалт семинарын зардал тайлант онд гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ		-	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал		-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тоо	2,700,959.8	2,317,982.4	Увс аймаг дахь Гаалийн газрын нь 2025 онд 77 орон тоотой 2,700,959.8 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас тайлант онд 66 орон тоотойгоор ажиллаж 2,317,982.4 мянган төгрөгийг ажилчдын цалин хөлс, урамшуулалд зарцуулсан байна.
7	Хэвлэл мэдээлэл		-	Хэвлэл мэдээллийн зардал гараагүй байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 169, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймаг дахь Гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 446,497.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс 446,497.8 мянган төгрөгийн алдааг зарлууллаа.

5.1 Залруулга

Увс аймаг дахь Гаалийн газар нь мөнгөн гүйлгээний тайланд нийт зарлагын дүнг 8700.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн, санхүүгийн үр дүнгийн тайланд 437,922.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг тусгаагүй, ажилчдад өгөх 75.0 мянган төгрөгийн өглөгийг данс бүртгэлд тусгахгүй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 14.4 дэх заалт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 14.4.2 дахь заалт "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3 дахь заалт "Бүх өр төлбөр" гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг тусгаагүй							1	437,922.8				
ажилчдад өгөх өглөгийн данс бүртгэлд тусгахгүй							1	75.0				
мөнгөн гүйлгээний тайланд нийт зарлагын илүү илэрхийлсэн							1	8700.0				
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	3	446,697.8	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2026 оны 02 сарын 10-ны өдөр

